



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-8</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>9-24</i>

<i>1. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>9-24</i>
---	-------------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
04 дүгээр сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 40 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Б.Бейсен, Х.Болорчулуун, Н.Ганибал, Ц.Идэрбат;
Чөлөөтэй: Ц.Анандбазар, Г.Мөнхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Өнөрболор.

Нэг. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, референт О.Дөлгөөнтуул, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Сонор, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал С.Цогтсайхан, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Ж.Батжаргал танилцуулав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр протоколд тусгайлан тэмдэглүүлж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын

өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Батжаргал: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Дамдинням, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Малчин” гэсний дараа “, мал бүхий иргэн /цаашид “малчин” гэх/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг үг хэлж, зарчмын зөрүүтэй санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан, Төслийн 5.1.2 дахь заалтын “амьдрах” гэсний дараа “бодлогын болон эрх зүйн орчин” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.3.бэлчээрийг улирлын онцлогтой уялдуулан ашиглах, хамгаалах, доройтлоос сэргийлэх, нөхөн сэргээх бодлогыг тодорхойлох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “гамшгийн эрсдэлийг урьдчилан тооцох,” гэсний дараа “эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үндэсний чадавхийг бэхжүүлэх” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.5 дахь заалтыг хасаж, 6.1.8 дахь заалтыг 7.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.6.тэжээлийн ургамлын тариалалт, тэжээлийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр” гэсний дараах “төсөв хооронд,” гэснийг хасаж, мөн зүйлд 6.2 дахь хэсэг нэмж, төслийн 6.2 дахь хэсгийн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэснийг хасаж, дугаарыг 6.3 дахь хэсэг болгож өөрчлөх.

6.2.Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг үг хэлж, зарчмын зөрүүтэй санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан, Төслийн 7.1.5 дахь заалтын “нийтлэг стандарт” гэснийг “байгалийн бүс нутгийн онцлогт тохирсон стандарт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Батжаргал: 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “малчдад таниулах, сурталчлах” гэснийг “боловсруулж, батлуулах” гэж, 7.1.4 дэх заалтын “малын үүлдэрээр” гэснийг “бүс нутгийн онцлогт тохирсон, баталгаажсан үүлдэр, омгийн малаар” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 8, 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Батжаргал: 6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг 9.1.4, 9.1.5 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.4.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах;

9.1.5.өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг малын тоо толгойтой уялдуулан хангах, өвөлжөө, хаваржааны малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Батжаргал: 7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “зээлийн зарцуулалт” гэсний дараах “, хяналтыг” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5, 10.1.6,10.1.7 дахь заалт нэмэх:

“10.1.5.өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;

10.1.6.малын гаралтай түүхий эдийн анхан шатны ангилалт, тордолт хийж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, стандарт техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх;

10.1.7.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх төлөвлөгөөг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталж, үе шаттай хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 11, 12, 13 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Батжаргал: 8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн Хууль хүчин төгөлдөр болох хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Ж.Батжаргал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн гарчгийн “Хурлын бүрэн эрх” гэснийг “Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж, 5.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “арга хэмжээг авч” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн “газрын бүрэн эрх” гэснийг “газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж 6.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “арга хэмжээг авч” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаа” гэснийг “арга хэмжээ” гэж, 7.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг зохион байгуулна.” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн ”үйл ажиллагаа” гэснийг “арга хэмжээ” гэж, 8.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг зохион байгуулна.” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн гаргасан, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 9.1.4 дэх заалтын “малчинд” гэснийг “малчин, мал бүхий иргэнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

2.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Байнгын хорооны дарга Ж.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн гаргасан, Газрын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “аж ахуйн нэгж, байгууллагад,” гэсний дараа “мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд 1 удаа 5 га хүртэл” гэж, 33.5 дахь хэсэгт “улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, эсхүл” гэсний дараа “мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл” гэж тус тус нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх ажлын хэсгийн саналд Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан саналыг тусгаж санал хураалт явуулав.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

3.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн гаргасан, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 00 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 11 цаг 40 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Батжаргал: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанд Жигжидийн Батжаргал, Жадамбын Бат-Эрдэнэ, Батсүхийн Саранчимэг, Гочоогийн Ганболд, Гонгорын Дамдинням, Нанзадын Наранбаатар, Ганзоригийн Тэмүүлэн, Цэвэгдоржийн Туваан, Цэдэндамбын Цэрэнпунцаг, Төмөртоогоогийн Энхтүвшин нар хүрэлцэн ирснээр хуралдаан эхлэх бололцоотой ирцийн хувь бүрдэж байна.

Тийм учраас хуралдааныг нээж байна аа.

Өнөөдрийн байнгын хорооны хуралдаанаар Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийхээр орж ирж байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүд бий юу? Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө.

Гишүүд хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүн алга

байна. Хэлэлцэх асуудлаа тогтлоо. Хэлэлцэх асуудалдаа орё.

Би зөвхөн хэлэлцэх асуудлаа ярьж байна аа. Харин хэлэлцэх асуудалдаа орлоо. Та саналаа хэлнэ. Тийм юм байхгүй ээ. Анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Ажлын хэсгийн танилцуулгыг та бүгддээ хийе.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Ул Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, гишүүдэд Дамдинням, Тэмүүлэн, Цогтгэрэл, Цэрэнпунцаг нар ажиллалаа.

Ажлын хэсэг 2024 оны 4 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд хуралдаж ажлын хэсгийн гишүүдээс гаргасан 12 зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хурааж Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна. Хуулийн төсөлд малчин мал бүхий иргэд хоршоо байгуулах, хоршоонд нэгдэх, бэлчээрийг улирлын онцлогт уялдуулан ашиглах, хамгаалах, доройтлоос сэргийлэх, нөхөн сэргээх бодлогыг тодорхойлох уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадвартай, бүс нутгийн онцлогт тохирсон, баталгаажсан үүлдэр, омгийн малаар сүргийг сайжруулахад малчдын хоршоодод

дэмжлэг үзүүлэх, өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг малын тоо толгойтой уялдуулан хангах, өвөлжсөө, хаваржааны малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалах, малын гаралтай түүхий эдийн анхан шатын ангилалд тордолт хийж, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, стандарт техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх зэрэг хуулийг зохицуулалтыг төсөлд нэмж тусгалаа. Ажлын хэсэг хуулийн төслийн 6.1.9-өөс төсөв хооронд гэснийг хасаж, төсөлд 6.2 дахь хэсэг шинээр нэмж, 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулахаар төсөлд нэмж тусгасан.

Мөн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн саналыг ажлын хэсгийн гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийн талаарх ажлын хэсгийн гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулья.

Дашизэвэгийн Амарбаясгалан Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга, Ганхүлэг ХХААХҮ-ийн дэд сайд ирээгүй байгаа юм уу? Ч.Дондогмаа ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төрийн бодлогын газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Э.Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Я.Эрдэнэсайхан ЖДҮ-ийн газрын дарга, С.Цогтсайхан Зээлийн батлан даалтын сангийн захирал, Д.Батсүрэн ЗГХЭГ-ын референт ийм ажлын хэсэг байна.

Энхбаяр гишүүн үг хэлье гээд байсан. Энхбаяр гишүүн микрофоныг өгөөрэй.

Б.Энхбаяр: Би асуулт асуухгүй, үг хэлнэ ээ.

Байнгын хорооны протоколд тэмдэглүүлж байна. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Энэ хуулийн төслийг өнгөрсөн 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар Засгийн газарт хэлэлцсэн.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг 4 сайд баталсан. Тэр дотор миний бие бас байгаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд. Хуулийн төслийг үзэл баримтлалыг батлах болон өнгөрсөн 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар тараагдаж хэлэлцэгдсэн төсөлд байгаагүй. Засгийн газрын хурал дээр нэмэхээр яригдаагүй, Засгийн газраар хэлэлцээний дараа Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын тухай хуульд заасны

дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын Их Хуралд өргөн барих хуулийн төслийг эцэслэн хянаж Улсын Их Хуралд өргөн барих зөвшөөрлийг өгдөг. Энэ өргөн барихаар Хууль зүйн сайдад хянагдсан төсөлд байгаагүй зүйл заалт өргөн баригдах явцад хуулийн хулгай болж хавчуургадаж орж Улсын Их Хуралд өргөн баригдсан байна.

Энийг би өчигдөр мэдлээ.

Тэр нь энэ хуулийн төслийн 6.2 дахь заалт байна. Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөнө өө гэдэг заалт. Энэ бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын төсөв батлах бүрэн эрхэд халдаж байгаа заалт гэдэг үндэслэлээр Хууль зүйн сайд энэ заалттай холбоотой асуудлыг хасах санал өгөөд тэрийг хүлээн зөвшөөрч үзэл баримтлал батлагдсан.

Гэтэл энэ Хууль зүйн сайдаас Улсын Их Хуралд өргөн баригдахад хүртэл энэ заалт байгаагүй, хамгийн сүүлийн төсөл дээр.

Тийм учраас төслийн энэ заалт бол Засгийн газраар хэлэлцэгдээгүй Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барихад хянагдаагүй ийм зүйл заалт орсон байна. Энийг би протоколд албан ёсоор тэмдэглүүлж байна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Монгол Улсын Засгийн газар өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн төсөл санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурал өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд хуулийн төслийн бүрдэл нийцлийг хянаад хэлэлцэх нь зүйтэй юм байна гээд оруулж ирсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын захирамж гарч энэ хуулийн төслийг шуурхай хэлэлцэх шийдвэр гарсан. Энэ дагуу Байнгын хороо хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг нь дэмжээд Байнгын хороонд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэх чиглэл өгсөн. Энэ дагуу Байнгын хороо ажлын хэсгээ байгуулж ажлын хэсэг дээрээ энэ асуудлаа яриад хуулийн төслийг сайжруулах бэлтгэлээ хангаж зарчмын зөрүүтэй саналуудаа бэлтгэж өнөөдөр Байнгын хороондоо оруулж ирж байгаа гэдгийг албан ёсоор мэдэгдье.

Төсөл өргөн баригчийн зүгээс Засгийн газрын кабинетаараа ажиллаж байна уу? Ажиллахгүй байна уу энэ чинь? Хууль зүйн асуудлаа хариуцсан сайд нь орж ирээд хэлэлцүүлгийн түвшинд явж байгаа хууль дээрээ өөр юм яриад байх юм. Энэ дээр тайлбар өгөөч.

Хэрэг эрхлэхийн дарга тайлбараа өгье. Ажлын хэсгийн 2 дугаар номер.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны дарга эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Засгийн газраас уламжлалт мал аж ахуйн тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн өргөн барьж нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр ингээд өргөн бариад өнөөдөр хэлэлцэгдээд явж байна аа. Мэдээж Засгийн газраас хуулийн төслийг өргөн барихдаа бүрэн бүрдлийг хангаж кабинетын зарчмаар ажиллах зарчмын дагуу өргөн баригдсан гэдгийг эндээ бас албан ёсоор хэлэх нь зүйтэй.

Уг хуулийн төсөл боловсруулагдаад явж байхад төсөл боловсруулах ажлын хэсгийн хүрээнд

Сангийн яамнаас энэ 6.1.9, 6.2 дахь заалт бол зайлшгүй байх шаардлагатай. Ингэж байж бас энэ ган зудын нөхцөл байдал дээр уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх нөхцөл боломж бүрдэх юм, үүсэх юм гэдэг энэ саналыг гаргасан. Эхний удаад Хууль зүйн яам дэмжээгүй санал ирүүлсэн. Энэ асуудлаар Засгийн газрын хуралдаан дээр танилцуулгыг хийж Ерөнхий сайд бүх нөхцөл байдлыг сонсоод энэ яамдын саналыг тусгаад нэн яаралтай горимоор өргөн барих нь зүйтэй гээд сүүлийн байдлаар алх тогшсон. Хурлын протокол болон бусад зүйл бүгд бүрэн хангаж байгаа. Мэдээж яах вэ энэ Энхбаяр гишүүний хувьд бол өмнө нь ковидын хуулийг хэрэгжиж байхад бас мөн адил энэ заалт дээр эсрэг байр сууриа илэрхийлдэг байсан. Зүгээр энэ байр сууриа Засгийн газрын гишүүний хувьд гаргасан. Ерөнхий сайд 2 удаа кабинетын зарчмаар ажиллана гэдгийг сануулсан байгаа.

Хэрвээ энд холбогдох асуудал үүсээд явсан тохиолдолд Засгийн газар кабинет дээрээ асуудлыг ярилцаж шийдвэрлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Би Батжаргал гишүүний хэлсэн саналтай нэг байна. Улсын Их Хурлын дарга захирамж гаргаад Байнгын хороо хэлэлцэх эсэхийг шийдээд, Улсын Их Хурлаар бас хэлэлцэх эсэх нь шийдэгдээд явж байгаа зүйл байгаа гэдгийг бас сануулж хэлье.

Ер нь Сангийн сайд ч бас энэ ажлын хэсгийн хурал дээр өнөөдрийн Засгийн газрын хуралдаан дээр хүртэл энэ асуудлыг бас мөн тодотгож хэлсэн байгаа. Анхнаасаа Сангийн яамны гаргасан санал байр суурь яг энэ бодлого зарчим дээрээ хатуу байгаа гэдгийг бас хэлье ээ.

Ж.Батжаргал: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д

Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу асуудлаа хэлэлцье.

Та бүхэндээ хуулийн төсөл, зарчмын зөрөөтэй саналын томъёоллуудаа хүргүүлсэн байгаа гэдгийг хэлье. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээ явуулъя. Хуулийн төслийн I дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байгаа юу? Алга байна. Туваан гишүүн.

Ц.Туваан: Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах гэж байгаа юм. Тэгэхээр энэ бол зайлшгүй ээ. Монгол Улсад сүүлийн 80 настай ахмад малчдаас асуухаар ийм өвөл зуд үзээгүй гэж байгаа юм. Тэгэхээр бол энэ үнэхээр гамшиг болсон. Энэ асуудлаар бид нар бас Их Хурлын гишүүний хувиараа ч тэр сөрөг хүчний хувиараа ч тэр маш олон удаа асуудлуудыг бол ярьж ирсэн. Тэгэхээр энэ хуулийн төсөл орж ирж байгааг бол дэмжиж байгаа.

Үнэхээр дэмжихээс ч өөр арга байхгүй болсон. Нөхцөл байдал маш хүнд байгаа гэдгийг хэлье. Тэгээд энэ хууль дээр энэ малчин гэсний дараа мал бүхий иргэн гээд бас энэ асуудал орж ирсэнд баярлаж байна. Яагаад гэхээр Монголд чинь малтай малчин хүн дээрээс нь мал бүхий иргэн гээд сумын төвд ажиллаж байгаа төрийн захиргааны, төрийн үйлчилгээний багш, эмч, тэтгэврийнхэн гээд бүгд л хөөрхий хэдэн малтай мал бүхий иргэн тулдаа энэ хүндрэлүүдийг давж байгаа.

Тэгэхээр энэ хүмүүсийн мал ч гэсэн энэ сөрөг нөлөөлөлд өртсөн зудад өртсөн. Тэгэхээр энэ энэ хууль өөрөө сөрөг нөлөөлөл бууруулах юм бол энэ хүмүүсийг ялгаварлаж битгий хандаач гээд мал бүхий иргэн гэдэг асуудлыг оруулаач гэдэг саналыг тавиад энэ дээр

орж ирсэнд нь талархаж байгаа. Тэгээд энд зүйл дээр бас нэг зүйл хэлчихмээр санагдаад байгаа юм. Юу гэхээр Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд дээрээс нь Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс 7 гишүүн санал гаргаад энэ асуудлыг тавьсан. Бүр явж явж нөгөө тов тогтоох дарааллаа ч авч чадахгүйгээр 2 сарын хугацаа өнгөрсөн.

Тэгэхээр бол энэн дээр бид нар бас гайхаж байгаа. Яагаад энэ асуудлыг тавихаар ингээд сөрөг хүчний тавьсан АН-ын бүлгийн тавьсан асуудлууд ингээд орохгүй байна гээд асуудлыг удаа дараа тавьж байгаа. Энэ дотор тодорхой асуудлууд байгаа юм аа. Тэр нь юу вэ гэхлээр малчны зээлийг тэглэх гээд маш олон хүн АН-аас энэ асуудлыг ярьж байгаад гайхаж байна гэж байгаа юм. Тэгээд гайхаад байх юм байхгүй энэ өөрөө дэлхийн ардчилсан тогтолцоотой улсууд ч гэсэн энэ байгалийн гамшиг гээд Засгийн газраас зарлачихсан энэ зүйл дээр ярихаас өөр арга байхгүй ээ. Бид нар бүх малчны зээлийг яриагүй 1.3 их наядын зээл гэж байгаа. Энэ дотор эрсдэл үүсчихсэн малаа өндөр хувьтай алдчихсан хүмүүсийн асуудлыг ярьж байгаа юм.

Тэгэхээр эхний асуулт бол энэ хууль хэлэлцэх эсэх ярьж байхад малаа 70 хувь, 70-аас дээш хувь хорогдуулчихсан гэж байгаа юм. Энэ асуудлыг би бол энэ 70 бол өндөр тоо. Энэ ер нь маш өндөр тоо шүү дээ. Тэгэхээр ядахнаа нэг 40 хувь, 50 хувь болгоод оруулж ирэх ийм боломж байгаа юу гэдэг асуулт асуусан юм. Энэ асуултаа дахиад давтаад асуучихъя.

Хоёрдугаарт нь бол энэ сөрөг нөлөөллийг үнэхээр бууруулах гэж байгаа бол энэ малын малчдын барьцаанд тавьчихсан байгаа малаа тэр чигээр нь хотоо харлуулаад болон

өндөр хувьтай алдчихсан байгаа хүмүүс чинь банкны зээлийн барьцаанд байхгүй ээ. Тэгэхээр энэ асуудал дээр энэ зээл тэглэх асуудал дээр ер нь ямар энэ хуульд орсон энэ асуудлыг шийдчих ийм зүйл заалт байна уу гэдэг 2 дахь асуулт байна.

Гуравдугаарт бол мэдээж сөрөг нөлөөллийг бууруулахад малгүй малаа өндөр хувьтай алдсан иргэдийн малжуулах хөтөлбөр дээр энэ хууль дээр ер нь яг ямар гаргалгаа байгаа юм бэ? Одоо тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад байгаа 22 тэрбумаас өөр асуудал цаашаа гарч ирж яригдах уу? Энэ хууль батлагдсанаар дагаж гарч ирэх юм уу? Дагалдах тогтоол энэ тэр дээр юм орох уу гэсэн ийм.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2. Ер нь бол энэ хуулийн 1 дүгээр зүйл бол хуулийн зорилтын л асуудал байгаа. Тэгэхдээ Байнгын хорооны гишүүн асуучихсан учраас тэр 3 асуулт дээр нь тов тодорхой хариулт өгчихье.

Д.Амарбаясгалан: Туваан гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт малчдын хэрэглээний зээлтэй холбоотой асуудал асууж байгаа Улсын Их Хурлын гишүүд бас орон нутгаар явж ажилласан. Газар дээрээ нөхцөл байдал бас амаргүй байна. Тэгэхээр малчдад бас энэ цаг үед нь бас тус дэм болж энэ зээлийн эргэн төлөлтөд анхаарал хандуул гэдэг энэ асуудлыг бол ер нь бүгд л ярьж байгаа юм. Ингээд Засгийн газраас хэрэглээний зээлийг нэг жилээр төлөлтийг хойшлуулах. Нэг жилээр хойшилж байгаатай холбогдуулж хуримтлагдсан хүүн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг бол Засгийн газар хэлэлцээд шийдвэр гаргаад өнгөрсөн 7 хоногоос эхлээд хэрэгжээд эхэлчихсэн байгаа. Тэр юу вэ

гэхээр нэг жилээр зээл төлөлт нь хойшилно, зээлийн хүү хуримтлагдана, хуримтлагдсан зээлийн хүүгийн 75 хувийг төрөөс төлж барагдуулна. 25 хувийг малчин өөрөө төлнө өө гэдэг нэг дэх зохицуулалтын асуудал явж байна.

Хоёр дахь асуудал малжуулах хөтөлбөртэй холбоотой асуудал яригдаад байгаа. Ер нь малчин руу чиглэсэн 3 зүйл байгаа. Нэг дүгээрт саяын хэрэглээний зээлийн энэ төлөлттэй холбоотой асуудал.

Хоёр дахь асуудал “Малжуулах хөтөлбөр”. 2024 оны улсын төсөвт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 22 тэрбум төгрөг малжуулах хөтөлбөрийн зориулалтаар батлагдсан. Тэгэхээр энэ мал тооллогын дүн гараад яг хэд хэчнээн мал зудад хорогдсон бэ хэдэн айл өрх малгүй болсон бэ 70-аас дээш хувийн хорогдолтой айл өрхийн тоо хэд байна вэ гэдгийг эцэслэн гаргасны үндсэн дээр тэр 22 тэрбум төгрөгийг хэрхэн яаж хуваарилах вэ гэдэг асуудал тухайн үед нь шийдэгдэнэ ээ. Энэ бол мал хорогдох байдал өнөөдрийн байдлаар зогсоогүй байгаа гэдгийг бас та бүхэн ойлгож байгаа байх гэж бодож байна.

Гурав дахь асуудал буюу ер нь мал аж ахуйн салбар цаашидаа яах юм бэ? Яг энэ бэлчээрийн байдлаар мал маань тарга тэвээргээ хангалттай авдаггүй, өвлийн хүйтнийг тэсэхгүй, цас зудын нөхцөл байдал дээр хорогдох байдал ихээр бий болж байна. Малчдын хувьд яг ийм байдлаар цаашидаа мал маллаж хөдөө амьдарна гэдэг бол бид цаашаа тэсэхийн аргагүй болж эхэллээ. Тэгэхээр энэндээ бодитой арга хэмжээг аваач гэж Засгийн газраас хийсэн социологийн судалгаанд бодитой гарч ирсэн байгаа. Тэгэхээр Засгийн газар мал аж ахуйн салбарт малчид маань нийлээд хоршоод анхан болон дунд шатын хоршоо байгуулах замаар хөрөнгө оруулалт хийх боломжийг нээж

өгөх үүднээс хөрөнгө оруулалтын жилийн 6 хувийн хүүтэй 3-аас 5 жилийн хугацаатай зээл олгох бодлогыг энэ уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнийхээ хүрээнд авах нь зүйтэй гэж ингэж төлөвлөгөө боловсруулаад үүнийг зохицуулах хуулийн төслийг Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр өргөн бариад өнөөдөр хэлэлцэж байна гэдгийг бас хэлье ээ.

Ж.Батжаргал: Тодруулга байхгүй. Хэлэлцэх эсэх биш байхгүй юу энэ чинь анхны хэлэлцүүлэг явж байгаа.

Тийм учраас 1 дүгээр зүйлтэй холбогдуулж ажлын хэсгээс санал байхгүй. Тийм учраас 1 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулттай зарчмын зөрүүтэй саналын томъёололтой гишүүн байна уу? Үгүй үгүй байхгүй. Ажлын хэсгээс санал байхгүй. 2 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт саналтай гишүүн байна уу? Ажлын хэсгээс нэг санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Малчин” гэсний дараа “, мал бүхий иргэн /цаашид “малчин” гэх/” гэж нэмэх. Санал хураалт.

Санал хураалт 63.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Туваан гишүүн.

Ж.Батжаргал: Тэгээд нэг зүйлийг бас хэлчихье ээ. Одоо энэ

хуулийн сая байнгын хороон дарга бас танилцуулга уншиж байна. Тэгээд би түрүүн бас үгнүүд хэллээ. Тэгээд юу хэлж байна гэхээр энэ сөрөг нөлөөллийг бууруулах гээд байна хууль. Энэ нэгэнт гарчихсан байгаа сөрөг нөлөөллийг. Тэгэхээр энэ дээр нэг тийм цаашдын уламжлалт мал аж ахуйд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд мэдээж чухал. Тэрийг бүгдээрээ мэдэж байгаа. Бид нар энэ энэнээс гадна Малчин өрхийн холбооны тухай хууль энэ тэр гээд энэ малтай холбоотой юмнууд ярьж байгаа.

Тэгэхээр одоо энэ хууль дээр бол би голчлоод манай Байнгын хороо ч гэсэн энэ одоо гарчихсан байгаа сөрөг нөлөөллийг бууруулах дээр тодорхой юм аваач гэдэг л саналаа хэлээд байгаа юм. Тэгэхээр энэ түрүүний миний хэлсэн зүйл тэр энэ малчны зээлтэй холбоотой асуудал тэр зээлийн хүүг хойшлуулах ч юм уу ингээд яг энэ зээлийг нь бууруулах тал дээр ямар асуудал байгаа юм бэ гэдэг нэг асуултыг бас энэ дээрээ дахиад асуучихъя.

Хоёр дахь нь бол анхаарах зүйл санал нь бол хэдүүлээ нэгэнт гарчихсан байгаа сөрөг нөлөөлөл дээрээ л анхааръя аа. Цаашидаа энэ хоршоо байгуулах бэлчээрийн асуудал тэгээд энэ эрсдэл даах чадвартай бүс нутагт тохирсон үүлдэр омог гээд энэ бол дараа дараагийн асуудлууд байгаа шүү гээд саналаа хэлчихье.

Ж.Батжаргал: Санал байна. 4 дүгээр зүйлтэй холбогдуулж ажлын хэсгээс санал байхгүй хэлэлцлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулж асуух саналтай гишүүн байна уу? Саранчимэг гишүүн.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр төслийн 5.1.2 дахь заалтын “амьдрах” гэсний дараа “бодлогын болон эрх зүйн орчин нөхцөлийг гэж өөрчлөх, найруулах”. Энэ дээр би бас тайлбар тавья гэж бодож байна.

Тэгэхээр хуулийн төслийн энэ 5.1.2 дээр малчин орон нутагтаа тогтвор суурьшилтай ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх гэсэн заалт бол Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжүүлэх арга хэмжээнд арай тохирохгүй томъёолсон байна гэж үзэж байна.

Тийм учраас Улсын Их Хурал ая тухтай амьдрах эрх зүйн орчин бодлого тодорхойлох түвшинд арга хэмжээ авч ажилладаг. Тэгэхээр энэ нөхцөл бүрдүүлэх гэсэн томъёолол шууд утгаараа гүйцэтгэх чиг үүрэг хэрэгжүүлэх Засгийн газар салбарын яамд орон нутгийн удирдлагын түвшинд хийж гүйцэтгэх ажиллагаа. Тийм учраас энэ 5.1.2 дахь заалтын амьдрах гэсний дараа бодлогын болон эрх зүйн орчин нөхцөлийг гэж гэх нэмэх саналтай байна. Ингэснээр энэ заалтыг илүү тодорхой болгож төрийн институцийн чиг үүргийг тодорхой болгож байгаа учраас та бүхнийг дэмжиж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Ж.Батжаргал: Төслийн 5.1.2 дахь заалтын “амьдрах” гэсний дараа “бодлогын болон эрх зүйн орчин” гэж нэмэх гэсэн саналын томъёолол гаргалаа. Энэ томъёоллоор санал

хураалт явуулъя, дэмжье гэсэн томъёоллоор.

60 хувийн саналаар дэмжигдлээ.

5.1.3 дээр ажлын хэсгийн санал байгаа. Бэлчээрийг улирлын онцлогт уялдуулан ашиглах, хамгаалах доройтлоос сэргийлэх, нөхөн сэргээх бодлогыг тодорхойлох гэж.

Санал хураалт.

60 хувийн саналаар дэмжигдлээ.

5 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт саналтай гишүүн байна уу? Ажлын хэсгээс 2 санал байна.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын “гамшигийн эрсдэлийг урьдчилан тооцох” гэсний дараа “эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үндсэн чадавхыг бэхжүүлэх” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.5 дахь заалтыг хасаж 6.1.8 дахь заалтыг 7.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“7.1.6 Тэжээлийн ургамлын тариалалт, тэжээлийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх.”

Санал хураалт.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Үндэсний үндэсний.

60 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр” гэсний дараах “төсөв хооронд” гэснийг хасаж, мөн зүйлд 6.2 дахь хэсэг нэмж, төслийн 6.2 дахь хэсгийн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэснийг хасаж, дугаарыг 6.3 дахь хэсэг болгон өөрчлөх.

6.2 Энэ хуулийн 6.1-ийн есөд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулна.

Санал хураалт дэмжье гэсэн томъёоллоор.

6 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 70 хувийн саналаар дэмжигдлээ.

6 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух санал хэлэх гишүүд байна уу? Саранчимэг гишүүн нэр тасаллаа. Саранчимэг гишүүн.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр төслийн 7.1.5 дахь заалтын “нийтлэг стандарт” гэснийг “байгалийн бүс нутгийн онцлогт тохирсон стандарт” гэж өөрчлөн найруулах саналтай байна.

Тэгэхээр энэ 2 дахь зарчмын зөрүүтэй санал дээрээ бас тайлбар

хийе. Энэ заалтад малын өвөлжөө, хашаа, саравч барих, ашиглах нийтлэг стандартыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах хэрэгжилтэд хянах тавих гэсэн гэсэн байгаа.

Тэгэхээр энэ нийтлэг стандарт гэдгийг бол өөрчлөх саналтай байгаа юм. Монгол улс хойноосоо урагшаа говь хээр, говь цөлийн гэсэн ийм өргөргийн 4 бүстэй. Мөн энэ бүс болгон байгаль цаг уур, гадаргын, ургамал, амьтны зэрэг гээд ингээд өөрийн гэсэн хэв онцлогтой. Тэгэхээр энэ бүс бүслүүрийн онцлогийг дагаад ургамалжилт, бэлчээрийн хэв шинж өөр өөр байх бөгөөд энэ малын сүргийн байриил ч ялгаатай байдаг.

Тийм учраас энэ малын өвөлжөө саравч барих нийтлэг стандарт баталж мөрдөх нь учир дутагдалтай гэж үзээд нийтлэг стандарт гэснийг байгалийн бүс нутгийн онцлогт тохирсон стандарт гэж өөрчлөх саналтай байна.

Дэмжиж өгнө үү. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Ажлын хэсгээс нэг санал байгаа. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “малчдад таниулах, сурталчлах” гэснийг “боловсруулж батлуулах” гэж 7.1.4 дэх заалтын “малын үүдрээр” гэснийг “бүс нутгийн онцлогт тохирсон баталгаажсан үүлдэр омгийн малаар” гэж тус тус өөрчлөх.

Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саранчимэг гишүүний зарчмын зөрүүтэй санал.

Төслийн 7.1.5 дахь заалтын “нийтлэг стандарт” гэснийг “байгалийн бүс нутгийн онцлогт тохирсон стандарт” гэж өөрчлөх.

Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 70 хувийн саналаар дэмжигдлээ.

7 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс санал байхгүй.

8 дугаар зүйл эхэлж дууслаа.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс нэг санал байна.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг 9.1.4 9.1.5 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“9.1.4.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах;

“9.1.5.өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг малын тоо толгойтой уялдуулан хангах, өвөлжөө хаваржааны малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалах;” дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Яагаад энэ орчны газар гэдэг үгийг авахгүй байгаад байгаа юм бэ?

70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Ажлын хэсгээс нэг санал байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “Зээлийн зохицуулалт” гэсний дараах “хяналтыг” гэснийг хасаж мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5, 10.1.6, 10.1.7 дахь заалт нэмэх:

“10.1.5.өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;

10.1.6.малын гаралтай түүхий эдийн анхан шатын ангилалд тордолт хийж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх стандарт техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх;

10.1.7.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх төлөвлөгөөг бүх гишүүдийн хурлаараа хэлэлцэн баталж үе шаттай хэрэгжүүлэх. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 хувийн саналаар дэмжигдлээ.

10 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Ажлын хэсгээс санал байхгүй.

11 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс саналгүй.

12 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Ажлын хэсгээс бэлтгэсэн 2 санал байна.

Энэ чинь яахаараа 2 санал байгаад байгаа юм.

Төслийн 13 дугаар зүйлийн хууль хүчин төгөлдөр болох хугацааг 2024 оны

4 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр өөрчлөх.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн хэл, найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар эшлэлийг нийцүүлэн өөрчлөх.

Хэн өгсөн юм, үгүй тэгээд өгөхгүй яагаад байгаа юм. Энэ чинь тэгээд 13 дугаар зүйл дээр юм уу? Энэ юу гэсэн үг юм? Зүйл, заалт бүрээрээ явж байгаа. Анхны хэлэлцүүлэг тэгж явж байгаа. Тэгэхээр тэрэн дээрээ л гарах ёстой зүйл заалт дээрээ л.

Хэлэлцээд өнгөрчихсөн байна шүү дээ. Тийм учраас хэлэлцэх боломжгүй.

Саяын хэлсэн саналын томьёоллоор санал хураалт.

70 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын нэг санал байна.

Төслийн 5 дугаар зүйлийн гарчгийн “Хурлын бүрэн эрх” гэснийг “Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж, 5.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “арга хэмжээг авч” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн “газрын бүрэн эрх” гэснийг “газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэж 6.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “арга хэмжээг авч” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаа” гэснийг “арга хэмжээ” гэж, 7.1 дэх хэсгийн

“үйл ажиллагааг зохион байгуулна.” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаа” гэснийг “арга хэмжээ” гэж, 8.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг зохион байгуулна.” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус өөрчлөх.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 80 хувийн саналаар санал дэмжигдлээ. Найруулгын санал явж байна.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Дагасан хууль тогтоомжийн төслийг хэлэлцэж эхэлье.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье ээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал гаргах гишүүд байна уу айн. Ганболд гишүүн энэ асууя.

Г.Ганболд: Энэ мал бүхий иргэн гэдэг ер нь яг ямар тодорхойлолт өнөөдөр байна аа. Одоо ингээд энэ зээлийн батлан даалтын сангийн 9.1.4 дэх заалт чинь ингээд малчинд гэж байсны энэ мал бүхий иргэнд 100 хувь ингээд Зээлийн батлан даалтын сангаас хариуцна гэхээр хөдөө 5 малтай, 3 малтай, малгүй хүн бараг байхгүй. Монголд сумын дарга нар, Засаг дарга нь ч тэр тамгын дарга нь ч тэр энэ Их Хурлын гишүүд дотор ч гэсэн ХОМ-ийг нь үзэх юм бол ер нь малгүй хүн байхгүй байх. Тэгэхээр энэ Зээлийн батлан даалтын санд л би сайхан санаа зовоод

байгаа юм. Тэгээд нөгөө малчид руугаа чиглэх гэж байгаа юм маань хэт хавтгайраад бүгдээрээ авах юм шиг л юм болох гээд байна л даа.

Мал бүхий иргэн гэвэл Монголд одоо яг өнөөдөр мал бүхий хэдэн сая иргэн хэдэн мянган иргэн байна аа? Мал бүхий иргэн. Мал бүхий иргэн гэдэг тодорхойлолтод яг ямар тодорхойлолт байна аа? Энийгээ нэг тодруулаад мал бүхий иргэн гэдэг суманд давхар төрийн алба хашиж байгаа малтай иргэн байвал яах вэ? Хөдөөгийн айлд нэг хэдэн малаа тавьчихсан хүн болгон л байгаа шүү. Тэгээд энэ хэт ингээд хавтгайрах гээд байна. Эсвэл мал бүхий иргэн гэдэг тодорхойлолтыг нэг жсоохон нарийсгаж гаргаж ирмээр байх юм. Хүн болгон орно шүү энэнд. Өрх болгон бараг малгүй эцэг эхээс 5, 3 мал өгчихсөн. Айл дээр 5 мал нь, 10 мал нь, 20 мал нь байдаг бүх хүн орно. Тэгээд энэ тодорхойлолтоор хэдэн 100 мянган мал бүхий иргэн байна. Нэг тоо хэлээд өгөөч.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн хэд юм? Ажлын хэсгийн 3.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг дээр бас энэ малчин, мал бүхий иргэн гэдэг асуудлыг бас тодотгох нь зүйтэй гэж үзсэн. Яагаад гэхээр бас Улсын Их Хурлын гишүүдийн гаргаж байгаа санал үндэслэлтэй байна гээд бас ажлын хэсэг дээр ярьсан юм. Учир нь энэ мал аж ахуйн салбарыг дэмжих зорилготой явж байгаа энэ бодлогод дан ганц малчин хамрагдах гэхээс илүүтэйгээр тодорхой хэмжээнд мал бүхий иргэн, мал аж ахуйн салбарыг дэмжиж ажиллах малын эмч нарын хоршоо байгуулагдахаас өгсүүлээд олон зүйл энэ дээр бас нэмэлтээр бий болох нөхцөл үүсэж байгаа учраас мал бүхий иргэд хамрагдах боломжтой гэж.

Хоёр дахь үндсэн том шалтгаан нь ер нь энэ хот суурин газар төв суурин газраас бас Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах хөдөө орон нутагт хүн амын төвлөрлийг бий болгох, эдийн засгийн өсөлт хөгжлийг бий болгох зорилготой энэ бас уялдаж явах боломжтой юм гэж ингэж үзсэний үндсэн дээр мал бүхий иргэн гэж орж байгаа. Мал бүхий иргэн мал бүхий этгээд гэж 2 төрөл бас байгаад байна. Ер нь бол одоо малын тооноос хамаараад.

Тэгэхээр мал бүхий иргэн гэдгээ илүү тодотгож өгөх нь нөгөө бусдаасаа нөгөө этгээд гэдгээс нь ялгаж, салгаж, нарийвчилж оруулж байгаа л хэлбэр юм байгаа юм. Тэгэхээр зөвхөн дан ганц малчин хамрагдаад явна гэдэг дээр энэ асуудлыг илүү жсоохон тодотгож өгсөн юм л гэж.

Ж.Батжаргал: Харин би саналаа авчихсан. Таны санал ирээгүй 13 дахь зүйл ярихаар орж ирж байгаа байхгүй юу.

Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байхгүй, алга байна. Ажлын хэсгээс нэг санал байгаа.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 9.1.4 дэх заалтын “малчинд” гэснийг “малчин, мал бүхий иргэнд” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 80 хувийн саналаар дэмжигдлээ.

1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай

гишүүд байна уу? Ажлын хэсгээс санал байхгүй.

2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хоршооны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Ажлын хэсгээс санал байхгүй.

1 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Ажлын хэсгээс санал байхгүй.

2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хоршооны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Ганболд гишүүнээр тасалъя. Ганболд гишүүн асуултаа асууя. Газрын тухай хууль.

Г.Ганболд: Энэ дээр нэг асуулт асууя. Мал аж ахуйн үйлдвэрлэл өргөн л дөө. Тодорхойлолт ч бараг байхгүй ч байж магадгүй. Одоо энэнтэй

холбогдуулаад ингээд байна шүү дээ нэг аялал жсуулчлалын газар дээр гүүний саамны сувилал амралт хийе. Энэ мал аж ахуйн үйлдвэрлэл мөн үү? Ийм хэлбэр рүү ороод явах юм бол энэ өөрөө утгаа алдаж эхэлнэ шүү, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ 5 га газраа нэг хоршоонд нэг үү, хоёр уу, гурав уу, дөрөв үү, арав уу? Нэг хүн хэдэн хоршоонд орж болохгүй вэ? Нэг үү, хоёр уу, гурав уу, дөрөв үү, тав уу? Ингээд энийг нэг жаахан хязгаарлахгүй бол энэ цоорхой болж эхэлнэ ээ.

Тэгээд энэ хэлбэрээр одоо ингээд л нэг гүүний сувилал янз бүрийн ингээд л нэг адуу малтай холбоотой морь мал унуулах ингээд л үйлдвэрлэл, мал аж ахуйн үйлдвэрлэл болоод л ингээд явах юм бол энэ уг нь анхнаасаа орж ирсэн нь бол малын тэжээл рүүгээ л жаахан чиглүүлээд явах уу эсвэл хэдхэн зориулалт заах уу? Үйлдвэрлэл ерөнхий болохоор ер нь юуг ч хамруулж болно шүү тийм ээ.

Тэгэхээр энийгээ нэг жоохон хэдүүлээ тодорхой болгохгүй бол сүүлд нь ингээд нэг үйлдвэрлэл гээд газар өгчихнө. Нөгөөдөх нь мушгин гуйвуулагдах юм бол өгсөн хүндээ ч хэцүү, авах гэж байгаа нь ч аргаа олно. Тэгээд энэ дээр нэг жаахан тодорхой хариулт өгөөч.

Ж.Батжаргал: Хариулъя 3 номер. Ажлын хэсэг.

Д.Амарбаясгалан: Манай Батжаргал гишүүн нэмж бас хариулт өгөх байх л гэж бодож байна.

Нэгдүгээрт, Ганболд гишүүн ээ ийм юм байгаа юм. Энэ хуулийн 1.1 дээр зориулалт нь маш тодорхой заачихсан байгаа.

Ер нь энэ хуулийг ерөнхий зориулалт энэ хүрээгээрээ л хязгаарлагдана гэсэн үг. Сөрөг нөлөөллөөс хамгаалах малчдад учирсан эрсдэлийг бууруулах арга хэмжээг онцгой журмаар шийдвэрлэхтэй холбоотой асуудал гэж, нэгдүгээрт орж ирж байгаа.

Хоёрдугаарт, ер нь энэ хоршооны үйл ажиллагааг цааш нь аваад эрхлээд тогтвортой явах нөхцөлийг бүрдүүлэх чиглэл дээр 3 зүйл дээр бид анхаарах ёстой байгаад байгаа юм. Энэ хуулиар үндсэндээ бол мэдээж хөрөнгө оруулалтын зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр урт хугацаанд зээлдүүлэх үндсэн зорилго хангагдаж явж байгаа. Цаашидаа энэ хоршоо өөрийн гэсэн хөрөнгөтэй үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийг бий болгох тэр хөрөнгөөрөө эргэлт бизнесээ эрхлэх ийм шаардлагууд үүсэж байгаа учраас тодорхой хэм хэмжээнд хоршоог хөрөнгөтэй болгох нэг дэх шаардлага бол гарч ирж байна.

Хоёрдугаарт, ер нь энэ мал аж ахуйн салбарыг дагаж урган гарч ирэх бизнесийн төрлийг бид заахад маш хэцүү. Энэ маш олон төрлөөр өргөжин тэлэх боломжтой. Тэр хэрээрээ энэ мал аж ахуйн салбараас улсын эдийн засагт ДНБ-д үзүүлэх нөлөөлөл цар хүрээгээ тэлнэ гэсэн энэ бодлого дээрээ тавьж ажиллах нь бол зүйтэй. Хэт их хумьсан бодлого энд хэрэгжүүлэх нь мал аж ахуйн салбарын ирээдүйн хөгжилд бас сөрөг нөлөөтэй байх талтай учраас олон талаар хөгжих тэр бодлогыг дэмжих нь энэ Улсын Их Хурлаас батлагдах хуулиараа илүү өндөр ач холбогдолтой байх юм аа.

Энэ салбарт магадгүй мал аж ахуйн салбарын төрөлд оруулаад гүүний аж ахуй, саам өргөжөөд ирэх тусмаа л улам бүүр л эдийн засаг үр өгөөж малчдын ажил амьдралд бол илүү

нөлөөтэй байх юм аа. Тэгэхээр энийг тодорхой хэмжээнд хязгаарлах нь зүй зохисгүй юм аа. Мал аж ахуйн салбарыг чинь дагаад зөвхөн мах биш болчхоод байгаа шүү дээ. Мах, малын түүхий эд, сүү сүүн бүтээгдэхүүн, газар тариалан, ногоон тэжээл бэлтгэл, мал эмнэлгийн салбарын хөгжил дагасан магадгүй МАА-тай уялдсан тодорхой хэмжээний аялал жуулчлал байхыг ч бас эндээ үгүйсгэж болохгүй гэж ингэж энэ талаасаа харж дэмжих боломжтой гэж үзэж байгаа юм.

Ж.Батжаргал: Тэр нэг малчин хэдэн хоршооны гишүүн энэ тэр байх вэ энэ тэр гэдэг хоршооныхоо хуулиар явна. Тэр хуулиараа явна. Зүгээр энэ газар олголтын асуудал дээр манай гишүүдийн гаргаж байгаа санал бас авууштай. Дам дамаан төсөл сонгон шалгаруулалтаар нэг удаа гэдэг үг зайлшгүй шаардлагатай болчхоод байгаа юм.

Тийм учраас энүүнийг бол зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо таныг гаргачихвал хураалгахад бэлэн байна гэж. Тэгэх юм бол илүү зохицуулалт нарийсаад би больчихож байгаа юм. Хоршоо нэг л удаа төсөл сонгон шалгаруулалтаар 5 хүртэл га газар авна. Өөр газар хэрэгтэй гэвэл дуудлага худалдаагаараа тэр явдаг зарчмаараа явна. Ингэж л эрхийг нь нээж өгөх нь зөв. Би тэгж ойлгож байна. Тийм учраас Ганболд гишүүн нэг удаа гэдэг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо гаргаад ирүүлчихвэл би санал хураалгахад бэлэн байна аа.

Юу юу юу Ганболд гишүүн ээ? Яг хэлэлцэж байгаа асуудлынхаа өнөө зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо өгчих. Газрын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс нэг санал бэлтгэсэн.

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “аж ахуйн нэгж байгууллагад” гэсний дараа “мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд 5 хүртэл” гэж 33.5 дахь хэсэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, эсхүл” гэсний дараа “мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл” гэж тус тус нэмэх ийм саналын томъёолол бэлтгэж ирсэн юм.

Саяын Ганболд гишүүний гаргасан санал зарчмын зөрүүтэй саналын томъёоллын нэг удаа гэдгийг авах ёстой газар нь авмаар байна

Та яагаад хурал үймүүлээд байгаа юм бэ

Ганболд гишүүний гаргасан саналын томъёоллыг ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томъёоллын 5 га гэдгийн өмнө “нэг удаа 5 га” гэж орж байгаа юм байна. Ийм саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 80 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн санал байхгүй.

2 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцье ээ.

Асуулт асуух саналтай гишүүд бий юу? Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг санал байна.

Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Ийм саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 80 хувийн саналаар тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах дэмжигдлээ.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Таны наад санал хуулийн төслийн 13 дугаар зүйлийг хэлэлцэж явах үед орж ирсэн. Наадах чинь 6 дугаар зүйлийн санал юм билээ. Тийм учраас ард үлдсэн. Одоо танд чуулганы хуралдаан дээр саналаа гаргаад санал хураалгах бололцоо нь байж байгаа. Хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Гонгорын Дамдинням гишүүн танилцуулна. Санал, дүгнэлтийг маргааш. Дамдинням гишүүн танилцуулна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг өндөрлүүлж байна.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүддээ ажлын хэсэгтээ баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:

*ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА*